

ДеФакто **ТОЙМ**

НҮҮРС АЧИЛТЫГ ТҮР ЗОГСООЛОО

МАХН-ЫН ДАРГА ХЭН БЭ

Б.ХУРЦЫН “НЭЭЛТТЭЙ”
СОНСГОЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР

VI НҮҮРТ

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

М.ШАГДАРСҮРЭН

АРХИЙГ БАГА ЗЭРЭГ
ШИНГЭЛЭЭД БАГА ЗЭРГИЙГ, 6-8
ГРАДУСЫН ВИНОГ 200-300 МЛ,
ШАР АЙРГИЙГ 300-400 МЛ

ХЭРЭГЛЭХ ЮМ БОЛ
ЭЛЭГ ШҮҮГЭЭД
ГАРГАЧИХДАГ

IV НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

АМИН ЧУХАЛ САЛБАР

Уул уурхай бол Монгол улсын амин
чухал салбар. Хүн ам цөөн, Улаанбаатар
хотоос бусад газраа маш сийрэг суурьшсан,
мал аж ахуй болон түүнээс гаралтай
цөөн бүтээгдэхүүнээс өөр үйлдвэрлэлгүй
монголчууд.....

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2017.12.20, №26

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

АМИН ЧУХАЛ САЛБАР





№ 410

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>



АМИН ЧУХАЛ САЛБАР

Уул уурхай бол Монгол улсын амин чухал салбар. Хүн ам цөөн, Улаанбаатар хотоос бусад газраа маш сийрэг суурьшсан, мал аж ахуй болон түүнээс гаралтай цөөн бүтээгдэхүүнээс өөр үйлдвэрлэлгүй монголчууд юуны өмнө байгалийн нөөцөө эрж олох, олборлох замаар анхан шатны капиталын хуримтлалтай болох гэж зүтгэж байна.

Тэр хуримтлалаар эдийн засгаа төрөлжүүлэх [солонгоруулах], тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээгээр олон улсын зах зээл дээр өрсөлдөх замаар валютын тогтвортой эх үүсвэртэй болж нийгэм, эдийн засгаа цаашид хөгжүүлэх баттай, үндэс сууриа тавих ёстой юм.

Харамсалтай нь бид эдүгээ хөрөнгө хуримтлуулах

байтугай, томоохон өрөнд орчихоод тэр үндэс сууриа тавьж чадахгүй, улс төржихөөс өөр бүтээж байгаа зүйл тун бага байна. Тийм ч учраас ажилгүйдэл, ядуурал нүүрлэж, иргэд нь гадагшаа дүрвэх эрмэлзэлтэй болов.

Уул уурхайн нөөцөө удирдаж чадахгүй, засаглал нь хариуцлагагүй, сул учир эрдэс баялгийн үр өгөөжийг төр засгийн нөөлөг дор цөөхөн айл хүртэж, хөдөө нь цөлжин эзгүйрч, нийслэл нь ажилгүй иргэд бөөгнөрч, хуучин машин бөглөрсөн тосгон болж, агаарын бохирдолт нь гамшиг авчраад байна.

Уул уурхайн салбарт юугаа, яаж өөрчлөх шаардлагатай, ямар эерэг эхлэл байгаа тухай хэлэлцэх цаг болжээ.

ЭРДЭС БАЯЛГИЙН ХАЙГУУЛ

Уул уурхайн салбарын үндсэн хоёр дэд хэсгийн эхнийх нь эрдэс баялгийн хайгуул юм. Улс орон бүр нутаг дэвсгэрийнхээ геологийн зургийг гаргаж, ямар төрлийн эрдэс, ашигт малтмал хаана байгааг аль болох тодорхой тогтоохыг хичээдэг. Геологи, геохими, геофизикийн судалгаа хийж ерөнхий зураглалыг нь эхэлж гаргаад, дараа нь тодорхой хэсэгт нь төвлөрөн эрэл хайгуул хийж нөөцийг нь нарийвчлан тогтоодог.

Тэгвэл монголын Засгийн газар нутаг дэвсгэрийнхээ 1:200 мянга масштабтай геологийн ерөнхий зураглалаа 2020 он гэхэд хийж дуусна. Харин ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50 мянга масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг 2020 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд, 2030 он гэхэд талд нь төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх зорилт тавьжээ.

Илүү нарийвчлалтай, жижиг масштабтай зураглал хийхэд маш их эрэл хайгуул хийж, ихээхэн хөрөнгө шаардлагатай учир манайх шиг том нутагтай улс гадаадын хөрөнгө татахад хүрдэг. Хөрөнгө татахын тулд бизнесийн таатай, ойлгомжтой, тогтвортой орчин бүрдүүлж дэлхийн олон оронтой өрсөлдөх хэрэгтэй болдог. Тэгээд ч хөрөнгө оруулагчид зөвхөн хайж олох гэж бус, олбол түүнийг олборлож, борлуулаад ашиг олох зөвшөөрөл нь баталгаатай бол ирдэг.

Хэрэв ямар нэг орд олбол нөөцийг нь тогтоохын тулд хайгуулаасаа хэдэн арав дахин илүү хөрөнгө оруулж, олон зуун өрөмдлөгө хийж, дээжийг нь

хөндлөнгийн байгууллагаар шинжлүүлж, хүдрийн тогтцын зургийг нь гаргадаг. Энэ хүртэлх ажлыг жижгэвтэр компани (Junior) гүйцэтгэж, хөрөнгийн зах зээл дээрээ хувьцаагаа гаргаж санхүүждэг.

Харин нөөцийг нь олон улсын жаягаар (JORC) тогтоосны дараа, тухайн ордыг олборлох эрхийг нь том, туршлагатай компани (Major) худалдан авч олборлолт эхлүүлдэг. Бага нөөцтэй, жижиг ордыг бол жижгэвтэр компани өөрөө олборлоод ашиг олж болно.

Монгол улсын УУХҮЯ нь манай нутаг дэвсгэр дээр хийгдсэн хайгуулын ажлын бүх тайланг цуглуулан авч, гео-мэдээллийн нэгдсэн сангаа баяжуулдаг.



ЭРДЭС БАЯЛГИЙН ОЛБОРЛОЛТ

Уул уурхайн хоёр дахь дэд салбар бол олборлолтын салбар. Ордыг нөөцийг нь бүрэн тогтоогоод, олборлох нь ашигтай гэж шийдвэл холбогдох дэд бүтцийг байгуулан, олборлолтоо эхэлдэг. Нөөцөөсөө хамаараад цөөхөн эсвэл хэдэн арван жил олборлолт үргэлжилнэ. Олборлох явцад байгалийг аль болох бага хөндөж, уурхайг хаасны дараа өмнөх байдалтай нь аль болох төсөөтэй болгож нөхөн сэргээх ёстой. Тэр ажлыг хийхийн тулд олборлолт эхлэхтэй зэрэгцэн тодорхой хөрөнгийг байгаль орчныг нөхөн сэргээх санд хуримтлуулах ёстой.

Уул уурхайн олборлолт түрүүлж томоохон хөрөнгө шаарддаг, хэдэн жилийн дараа олборлолт эхлэхэд борлуултын орлого нь ирдэг учир хууль эрхийн болон бизнесийн урт хугацааны тогтвортой байдлыг шаарддаг. Ордын нөөц том байх тусмаа цахилгаан, ус, төмөр зам гэх мэт томоохон дэд бүтэц байгуулах болдог.

УУЛ УУРХАЙ ДАХЬ ШИНЭ ХАНДЛАГУУД

Манай төр засаг түргэн солигдож, уул уурхайн хууль журмаа олон удаа өөрчлөн, алдаж онож яваа ч энэ салбаргүйгээр монголын эдийн засгийг төсөөлөх аргагүй болжээ.

2017 оны эхний 11 сардуул уурхайн салбараас улсын төсөвт нийт 9 төрлийн татвар, төлбөр хэлбэрээр 1.4 их наяд төгрөг төвлөрүүлсэн нь төсвийн орлогын 20 хувьтай тэнцжээ. Энэ нь өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 764 тэрбум төгрөгөөр буюу хоёр дахин өсчээ. Мөн оны эхний 10 сарын байдлаар улсын нийт экспортын бараг 80 хувийг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт эзэлжээ. Эрдсийн экспорт өмнөх оны мөн үеийнхээс 1.5 тэрбум ам.доллараар өссөний 85 хувь нь нүүрснийх ажээ.

Уул уурхайн холбоотой олон асуудлууд тодорхой биш болсон учир орон нутгийн иргэдтэй зөрчилдөөн гарах болсон бөгөөд ихэнх нь уул уурхайн компаниудын төлсөн татвар, төлбөрийг төр засгаас орон нутагт нь тогмол олгодоггүйгээс үүдэлтэй. Нөгөө талаас олборлогч компаниуд санаачлан, нийгмийн хариуцлагаа ухамсарлан тодорхой төслүүд хэрэгжүүлэх болсныг тэмдэглэх хэрэгтэй.

Жишээ нь Оюу толгой компани орон нутгийн хөгжилд зориулан жил бүр 5 сая долларыг Говийн Оюу хөгжлийн сан нэртэй төрийн бус байгууллагаар дамжуулан 2015 оноос эхлэн олгох болжээ. Өмнө нь орон нутгийн хөгжилд зарцуулж ирсэн хөрөнгийн жилийн дунджаар тооцсон энэ мөнгийг хэрхэн зарцуулахыг компанийн болон аймаг, орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагууд хамтран шийдэж байна. 13 гишүүнтэй Харилцааны Хорооны шийдвэрээр 2015 онд гэхэд Даланзадгадад хоёр цэцэрлэгийн барилга, хоёр сургуулийн биеийн тамирын заал, Баян-Овоо суманд эрүүл мэндийн төв, Ханбогд суманд сургууль, цэцэрлэгийн барилга, сум дундын малын эрүүл мэндийн төв, Манлай суманд

Уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг маш нарийн, бодитой тооцоо хийж хөрөнгийн зах зээлээс босгодог. Санхүүжүүлэгчид бүх эрсдлийг нь дахин дахин тооцож, хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийдэг. Туршлага, түүхтэй, олон улсад нэр хүндтэй томоохон олборлогч компаниуд том төслүүдийг амжилттай хэрэгжүүлдэг.

МОНЦАМЭ-ийн мэдээлснээр 1990 оноос хойш 27 жилд манай улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нийтдээ 19 тэрбум америк долларын хөрөнгө орж ирсний бараг 80 хувь нь ганцхан уул уурхайн салбарт ногдож байна. Голланд, Хятад, Англи, Сингапур, Канад зэрэг улсууд тэргүүлсэн 112 орны 13 мянган аж ахуйн нэгж манайд байгуулагдан 38 мянган ажлын байр бий болгосны 80 хувийг дотоодын ажиллагсад эзэлж байна.

уурын зуухны барилга барьж ашиглалтанд өгчээ. 2016 онд Ханбогд суманд ундны ус цэвэршүүлж, хангах байгууламж, мод үржүүлгийн газар, хүнсний ногооны хүлэмж, ойн төгөл барих зэрэг олон төсөл хэрэгжүүлээд байна.

Говийн бүсийн гүний усны менежментийг сайжруулах төслийг Австралийн Засгийн газрын тусламжийн 4.2 сая америк доллараар Дэлхийн Банк 2013 оноос хэрэгжүүлж байгаа нь уул уурхайн олборлолтод холбоотой олон маргааныг бодитой шийдвэрлэх, усны ухаалаг менежментийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боллоо. Монгол улсын нутаг дэвсгэрт нийт 29 голын сав газар байдгаас гурвынх нь [17 аймгийн 99 сум, нийслэлийн нэг дүүргийн нутаг дэвсгэрийг буюу бүх нутгийн 34 хувь] гүний усны чанар, урсгалын эзлэхүүн болон түвшний хэлбэлзлэл, уул уурхайн ашиглалтын явцыг хянадаг 114 цооногон цэгийг ашиглан мэдээллийг цуглуулсан систем бий болгоод байна.

Бороогийн уурхайн олборлолтын нөлөөгөөр үүссэн ухаш буюу ил уурхайн 92.7 га талбайг нөхөн дүүргэж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт бүрэн хийх боломжгүй тул экологийн ижил төстэй газарт дүйцүүлэн хамгаалах ажил хийжээ. Олборлолтын өмнө байсан 77.5 га бэлчээр газар, 15.2 га ойн экосистемийн оронд 160.4 га бэлчээрийн, 45.7 га ойн экосистемийн талбайд “сайжруулалт ба нөхөн сэргээх” ажил хийж байна.

Монголын уул уурхайн олборлогч компаниудын нийгмийн хариуцлага дээшилж байгаа ч энэ салбарт мэдээлэл, мэдлэгтэй хэлэлцүүлгийг иргэдийн дунд улам өргөн явуулснаар энэхүү амин чухал салбарын олон асуудлыг түргэн шуурхай шийдэх боломж бүрдэх ажээ.

2017.12.20



М.ШАГДАРСҮРЭН

МУ-ын гавьяат эмч, доктор,
профессор

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Монгол, англи, орос хэл дээрх ярилцлага, <http://jargaldefacto.com/category/8>

АРХИЙГ БАГА ЗЭРЭГ ШИНГЭЛЭЭД БАГА ЗЭРГИЙГ, 6-8
ГРАДУСЫН ВИНОГ 200-300 МЛ, ШАР АЙРГИЙГ 300-400 МЛ

ХЭРЭГЛЭХ ЮМ БОЛ ЭЛЭГ ШҮҮГЭЭД ГАРГАЧИХДАГ

Монгол улсын гавьяат эмч, доктор, профессор М.Шагдарсүрэн нь Монгол ба Япон улсад мэргэжлээрээ суралцаж төгссөн ба АНУ, БНСУ, Австри, Франц, Хятад зэрэг олон оронд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан. Тэрээр олон нийтэд "элэгний Шагдарсүрэн" гэж алдаршсан бөгөөд одоо "Шагдарсүрэн" нэртэй элэгний эмнэлгээ ажиллуулж байна. Япон, Хятад хэл эзэмшсэн тул орчуулагч эмчээр ажилладаг ба хэд хэдэн ном хянан тохиолдуулсан орчуулагч хүн юм.

Ж: Монголчууд элэгний өвчлөлөөр дэлхийд тэргүүлж байна. Үүний шалтгаан юу вэ, мөн зогсоох боломжтой юу?

М.Шагдарсүрэн: Элэгний үрэвсэл буюу гепатит нь цаашдаа элэгний хатуурал, бүр хүндрэхээрээ хорт хавдар болж хувирдаг. Хорт хавдрыг 100 мянган хүнд хэд тохиолдож байгаагаар нь ангилдаг. Жишээ нь, цөөхөн тохиолддог орнуудад 10 гаруй, Хятадад 28, Африкийн орнуудад 50 гаруй, харин манай оронд 100-110 байгаа нь жагсаалтын нэгдүгээрт орж байгаа юм. Элэгний өвчлөл үүсгэдэг гол шалтгаан нь вирус юм. 10 гаруй төрлийн вирус байдгаас монголд өргөн тархсан нь 3, 4 төрлийн вирус байна. В, С вирус ихэнхийг нь буюу 90 гаруй хувийг эзэлдэг. Би энэ тухай яриад, элэгний өвчлөлийг судлаад 30 гаруй жил болж байна. 1950-1960 оны үед тарианаас халддаг гэдгийг мэдэлгүй стерилизаторт буцалгаж ариутгаад тарьдаг байснаас эхэлж тархсан гэдэг үнэн. Вирус гэдэг нь бидний мэддэг нян, бактериас маш өөр бүтэцтэй, 10-20 сая хуваасантай тэнцэх тийм жижигхэн учраас түүнийг буцалгаад устгаж чадахгүй байгаагаа мэдэх боломжгүй байсан үе л дээ. Энэ нь тухайн үедээ төдийлөн мэдэгдэхгүй байсан боловч элэгний үрэвсэл буюу гепатит, цаашлаад элэгний хатуурал буюу цирроз, түүн дээрээ сууриалаад хавдар үүссэнээр бидний энэ дэлхийд байхгүй их хорт хавдар, өвчлөлийг үүсгэсэн байгаа юм. Одоог болтол тийм амархан эмчлэгддэггүй байгаа.

Ж: Үндэсний хэмжээнд гамшиг болтлоо өвдсөний дараа нэг юм ойлгоод одоо боломжтой нэг нь эмчлээд байна. Тэгэхээр нэгэнт өвдсөн бол яаж эмчлэх вэ? Буцалгадаг тарианы үеэс хойш үеийн хүмүүс элэгний өвчнөөр өвдөхийг зогсоож чадсан болов уу?

М.Шагдарсүрэн: Зогсоож чадаагүй байна. Гэхдээ 1950-1970-аад оныг бодвол дэлхий дахинд харьцангуй дэвшил гарчээ. Сүүлд С вирусыг эмчлэх аргыг бараг 100 хувь нээсэн. В вирусээс урьдчилан сэргийлэх вакциныг нээснийг манай оронд 1992 оноос эхлэн тарьж эхэлсэн тул 100 хувь эдгээж чадахгүй ч В вирусээс урьдчилан сэргийлэх нь илүү үр дүнтэй байгаа юм. С вирус

ихэвчлэн арьс, салст бүрхэвч буюу зүү, тариа, бэлгийн зам, мэс заслаар; мөн мэс ажилбарууд буюу шүд авахуулах, зүү тавиулах, шивээс хийлгэх; цаашлаад шүдний сойз, сахлын хутга зэрэг ахуйн хэрэглээгээр халддаг.

Ж: Жилд нэг хүн ууж байгаа архиныхаа хэмжээгээр бид дэлхийн том орнуудтай тэнцэх хэмжээтэй байгаа. Архи, пиво, вино гээд олон янзын согтууруулах ундаануудын үзүүлэх хор нөлөө хэр байдаг юм бэ?

М.Шагдарсүрэн: Элэгний өвчнийг үүсгэдэг вирус архи хэтрүүлэн хэрэглэх, эмийн зохисгүй хэрэглээ болон буруу хооллолт гэсэн үндсэн шалтгаануудтай. Градусын хэмжээ их байх тусмаа биед хортой байх гэж бодож байна. Архийг бага зэрэг шингэлээд бага зэргийг, 6-8 градусын виног 200-300 мл, шар айргийг 300-400 мл хэрэглэх юм бол элэг шүүгээд гаргачихдаг. Тухайн хүний жин, хувийн онцлогоос шалтгаалаад хэтрүүлэн уувал хор нь биед үлдээд элэгний эд, эсийг гэмтээдэг. Бас нэг монголчуудын онцлог бол архийг хоосон ходоодон дээр уудаг. Хятад архинууд маш их градустай, даршилсан байдаг хэдий ч тохируулж уувал стресс тайлж, хоол шингээдэг, эмчилгээний үйлчилгээтэй байдаг.

Ж: Эмийн хэрэглээний тухай ярья. Сөүлд хотын булан бүрт нэг юмуу хоёр кофе шоп байдаг байхад Улаанбаатар хотын булан бүрт нэг юмуу хоёр эмийн сан байдаг. Бид эмийг хоол шиг идэж байна. Үүнийг яах вэ?

М.Шагдарсүрэн: Эмийг ингэж замбараагүй хэрэглэдэг орон байдаггүй байх. Эмийг ер нь зорьсон өвчиндөө хэрэглэхээс бусад үед хор гэж үздэг. Тун хэтрэх юм уу удаан хэрэглэх юм бол ялангуяа элгийг хорлодог. Ялангуяа уушиг, сүрьеэ, жирэмслэхээс хамгаалах, нойрны эм, антибиотикууд болон өвчин намдаах парацетамол болон цитрамон зэрэг нь маш хортой. Манайд эмчийн тодорхойлолтгүй эм өгдөг бол өөр оронд огт өгдөггүй. Аргагүй шүү дээ, эм хүний элэг, бөөрийг гэмтээж байна. Тун хэтэрвэл аюултай байна.

Ж: Эмнэлгийн бүх шатны байгууллагуудад ажиллаж байсан хүний хувьд эмийг бизнес болгосон явдлыг юу гэж бодож байна? Импортлож байгаа хүмүүс нь бүгдээрээ эрүүл мэндийн яамтай холбоотой, эмч нар нь тэндээс тийм эм уу гэж хэлж байгаа энэ том тойргийг бид хаанаас нь зогсоох вэ? Энэ тухай бичсэн сонин, сэтгүүлчдэд мөнгө өгөөд чимээгүй болгочихдог. Үүнийг яах ёстой вэ?

М.Шагдарсүрэн: Энэ бол их хэцүү асуудал юм. Ялангуяа сүлжээний эм хэрэглэснээр бодисын солилцоог хүчээр өөрчилдөг, ингэснээр элэг мууддаг. Бага анги, цэцэрлэгээс нь эрүүл мэндийн боловсролыг эзэмшүүлэх бодлого хангалтгүйгээс эрүүл мэндийн боловсрол маш муу. Боловсрол олгодоггүй юм аа гэхэд аль нь хортойг заагаад өгчихдөг байх хэрэгтэй. Солонгос, Японд гэхэд жирийн ард нь ямар загас, ногоо юунд сайныг маш сайн мэддэг.

Ж: Орж ирж байгаа бүтээгдэхүүнийхээ нитрат, хадгалах бодисын хэмжээ, шошгон дээрх мэдээлэл нь үнэн үү гэдгийг лабораториар шинжлэх хэрэгтэй байна. Мөн хүүхдүүдээ мэдлэгтэй болгох хэрэгтэй байна шүү дээ.

М.Шагдарсүрэн: Халуун ногоо, халуун чинжүү ходоодны үрэвслийг сайжруулдаг, туранхай хүмүүст жин нэмдэг, хоол боловсруулалт сайжруулдаг, хамгийн чухал нь үржлийн чадвар маш сайжруулдаг. Гэтэл манайд ямар үзэл байна вэ гэхээр халуун ногоотой хоол ходоодонд муу, бага идэх хэрэгтэй гэдэг. Үүнийг би өөрчлөх хүсэлтэй.

Дээр үед халуун чинжүүгээр тамир сайжруулах эмчилгээ хийдэг байсан. Чинжүү галзууруулна гэж шар тосонд жигнээд өгөхөд бие сайхан болдог гэж байгаа.

Ж: Хүмүүс ихэвчлэн таны тухай ярихдаа элэгний тухай ярьдаг, харин та өөрөө яруу найрагч, мэргэжлийн орчуулагч, олон улсуудаар явсан, мэргэжил дээшлүүлсэн туршлагатай хүн. 10 мянган хүнд хэвлий, цээжний мэс засал хийж байсан. Элэгний өвчлөлөөр мэргэшихээс гадна орчуулгын тал дээр “Анагаах ухааны монгол-англи, англи-монгол толь бичиг”-ийг гаргасан байна. Үүнийг хийх сэдэл нь юу байв, мөн хэр удаан хугацаанд хийж гүйцэтгэв?

М.Шагдарсүрэн: 1970 онд намайг оюутан байхад анагаахын байтугай зүгээр Англи-Монгол толь ч гэж байдаггүй байсан. Ном уншихаар дандаа Орос-Англи тайлбаруудтай, Японд Цукубагийн их

сургуульд Япон хэл заалгаж байхад мөн дандаа англиар заадаг байсан тул заавал Англи хэлээр дамжих шаардлагатай байдаг байлаа.

Ж: Таны орчуулсан номны дунд Омар Хайям байна. Яагаад үүнийг гаргах болов?

М.Шагдарсүрэн: Омар Хайям бол 1000 жилийн өмнөх Персийн эмч хүн. Тэр үеийн эмч нар яруу найраг, зурхай, гүн ухаан зэрэг их таван ухаантайгаа холбогдохгүй бол явж өгдөггүй байсан байна. 10 гаруй жилийн өмнө орчуулагдаж гараад шагнал авч байсан ном шүү.

Ж: Та өөрийнхөө гаргасан номнуудын тухай ярьж өгөөч.

М.Шагдарсүрэн: Энэ бол “Элэгний өвчний эмчилгээ болоод хоол эмчилгээ” гэдэг ном бөгөөд Монгол хэвлэл нь дууссан учраас Япон хэвлэл нь байна. Хятадад “Элэгний өвчний эмчилгээ болоод хоол эмчилгээ 365 хоног” гэсэн ном гарсан нь мөн дуусчихсан. Харин энэ ном бол 6000 гаруй үгтэй ургамлын толь юм. 70, 80 настай хөгшин хүмүүст хоол зохиогүйн улмаас хагалгаа хийж чадахгүй, гарах гарцгүй үед Япон, Хятадаас жор олсон юм. Гэтэл орчуулгын ямар ч толиноос олддоггүй. Тийм учраас би ийм ном гаргасан юм.

Ж: Ийм олон ном гаргаад, 10 мянган хүнд хагалгаа, 400 гаруй мянган хүнд үзлэг, оношлогоо хийсэн гэж байгаа. Та яаж ингэж ажилладаг юм бэ?

М.Шагдарсүрэн: Хүмүүс ингэж их асуудаг ч гэсэн би өөрийнхөө бодож байснаас илүү залуу хойрго зангаар хийсэн гэж боддог. Би залуугаасаа 5 цагт босч сурсан учраас их ажил амжуулна. Ном орчуулахдаа эхний 15-20 хуудсыг үг үсэггүй толь бичгээс хайчихвал цаашдаа илүү хөнгөрөөд байдаг. Өдөрт 100 үг бичээд 70 гаруйг нь цээжилж байсан удаатай. Япончуудын ажиллаж байгаа хэв маяг надад их урам өгсөн. Эмч хүн дандаа өвчин судлаад, цус үзээд суугаад байж болохгүй л дээ. Ялангуяа яруу найраг гэдэг бол маш нарийн ухаан шаардсан тансаг эд.

2017. 11. 01

Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/m-shagdarsuren-shagdarsuren-manaljav> холбоосоор үзнэ үү.

Татгалзахын аргагүй САНАЛ

FORD EXPLORER

JAGUAR F-PACE

RANGE ROVER

1-2 ton FUEL

WINTER TIRE

TRAVEL VOUCHER

iPhone X

SERVICE

TEL: 99118301, 99106507, 99118375
www.waa.mn

WAGNER ASIA AUTOMOTIVE LLC



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2017.12.17-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://fargaldefacto.com/category/12>

НҮҮРС АЧИЛТЫГ ТҮР ЗОГСООЛОО



Гашуун Сухайтад үүссэн нүүрс тээвэрлэгч автомашины урт цувааг багасгах зорилгоор Таван толгойн ордуудад ажиллаж байгаа компаниудын ачилтыг 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар зогсоох шийдвэрийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд гаргасан.

Энэ асуудлын уг суурь нь дээр үеэс л эхэлсэн. Манай уул уурхайн салбарын менежмент дампуурсан байдалтай байгааг л харуулж байна. Төр стратегийн гэх орд газруудтай болсноос хойш орд газрууд хариуцлагагүй ажиллаж, уул уурхайн компаниуддаа хяналт тавьж чадахаа больсон. Хяналт тавьж чадахгүй байгаа болохоор Таван толгойн улсын орд ба орон нутгийн Таван толгой хоёр нийлж нэг нь ордыг олборлож, нөгөө нь өөрийн дураар ангилж үнэлээд тодорхой биш тайланг гаргаж байгаа гэж яригдаад байна. Энержи Ресурсаас хамаагүй хямд үнээр уурхайн аман дээр борлуулалт хийж уурхайн аманд л нүүрсээ өгөөд цааш хариуцахгүй болсон гэсэн үг л дээ. Тийнхүү эхлээд хятадын машин өөрөө хүрч ирээд аман дээрээс нь худалдан авах боломжтой гэрээ хийсэн буюу уг нь зүй нь бол орд газрыг олборлож буй компани экспортод гаргах хүртэл бүрэн хариуцах ёстой л доо. Тэгээд нутгийнхан нь гадаадын жолооч явж байгаа тухай гомдол гаргасны үр дүнд хятадын жолооч явж болохгүй гэмэгц хятадын компаниуд

монгол жолоочийг хөлсөлж аваад татваргүйгээр буюу нүүрсээ аваад ирвэл мөнгийг чинь өгье гэсэн зарчим бий болж эхэлсэн. Үүнээс болж маш замбараагүй байдал бий болж, энэ нь ужиграсаар өнөөдрийн байдалд хүрээд байна.

Авто тээврийн үйлчилгээний газар гээд төрийн өмчит газар нь машины зөвшөөрөл өгдөг байгууллага атал тэд тооцоогүйгээр өдгөө 125 аж ахуй нэгжид, 7870 тээврийн машинд зөвшөөрөл олгосон байгаа юм байна. Тэр машинууд 100 км зогсоно уу энэ хүмүүст хамаагүй, уурхайдаа бол бүр ч хамаагүй ачиж л байвал болно. Үүний үр дүнд нь 7000-8000 монгол жолооч 14-20 хоног машиндаа унтаж байна. Энэ бол 21-р зуунд байж боломгүй хариуцлагагүй тооцоо. Ингээд иргэд зовлонг нь үүрсээр аргаа бараад зогсоолоо. Нүүрсний компаниуд хил гарахгүй байхад тэртээ тэргүй алдагдал хүлээж л байгаа. Ер нь бол гарахгүй байгаа “гацчихсан юмыг” зогсоох л хэрэгтэй шүү дээ, хүмүүсийг наана нь хонуулах ямар шаардлага байгаа юм?

Хариуцлагатай уурхай бол хайх, олборлох, зөөх, хил гаргах, худалдах гээд бүтнээр нь хариуцахыг хэлдэг. Төр өөрөө хариуцлагагүй, авлигад идэгдсэн байгаа учраас тэр олон жолоочийн тав тух, хөдөлмөрийн аюулгүй байдлыг алдагдуулан байж төлж байгаа юм.

МАХН-ЫН ДАРГА ХЭН БЭ?



Гэрэл зургийг vip76.mn



Гэрэл зургийг zuv.mn

УИХ-ын гишүүн О.Баасанхүү МАХН-ын их хурлыг зохион байгууллаа. УИХ-ын гишүүн О.Баасанхүүгийн зохион байгуулсан 1000 гишүүний хурлыг МАХН-ын дарга Н.Энхбаяр, С.Ганбаатар нар хүчин төгөлдөр биш гэж үзэв. Уг хурлаар Н.Энхбаярыг намын даргаас огцруулсан. Тэгэхээр хэн нь намын дарга болсон нь тодорхойгүй байна.

Монголын улс төрийн намууд төрийн эрхийг авдаг ганц институт атал байгууллын хувьд бэхжихгүй байгааг л харуулж байна. Баабар төрийн эрхийг барьж байгаа хоёр намыг “төрийн тогтолцоог нураан сүйтгэгч, голлон бузарлагч” гэж хэлсэн байна лээ. Институтын хувьд бэхжиж чадахгүй, нам доторх манлайлагчдынх нь ярьсан хийсэн зүйл нийцэхгүй, санхүүжилтээ нуудаг зэргээс болоод “мафийн, хувийн хөрөнгө” шиг бүтэц бий болчихлоо.

Зарим намын гишүүд аль нам битгий хэл нам дотроо хэнийг нь дэмжвэл хурдан дэвших вэ гэсэн бодолтой

болсон байна. Ер нь нам дагаад л дарга болно гэсэн бодол их богино л доо. Улс орноо өөрчлөх, удирдах үйлсэд оролцоно, хараа нь болно гэж бодохгүй байх шиг байна. Би яах гэж намын гишүүн болсон юм бэ гэдэгт хариу өгөх хэрэгтэй. Нөгөө талаас улс төрийн нам бол аль нэг хүний өмч бус харин гишүүдийнхээ үзэл бодлыг илэрхийлсэн төрийн эрхийг авах зорилготой институт юм.

Хэрэв төрийн эрхийг барьж байгаа хоёр намд саад болох улс төрийн шинэ хүчин гарах юм бол ямар нэг шалтгаанаар зогсоох, бүртгэхгүй байх гэсэн логик ажиллаад байгаа. Тийм учраас энэ хоёр намаас өөр нам бий болох, өсөх зам үндсэндээ хаалттай байгаа. Дээд шүүх дуугарах асуудалдаа дуугардаггүй хэрнээ аль нэг улс төрийн нам төрийн эрхийг хууль бусаар авна л гээгүй бол юу хийх, хэнийг сонгох нь дотоод асуудал гэдгийг үл харгалзан санаатайгаар шинэ хүчнийг устгах бодлого явуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Б.ХУРЦЫН**“НЭЭЛТТЭЙ” СОНСГОЛ**

Гэрэл зургийг sonin.mn

12 дугаар сарын 15-ны өдөр Б.Хурцыг БНСУ-д суух элчин сайдаар томилох асуудлаар нээлттэй сонсгол зохион байгууллаа. Мөн яг энэ үеэр УИХ-ын танхимд Б.Хурцыг томилох асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцлээ. Нээлттэй сонсголд Ж.Батзандан, Лу.Болд, А.Сүхбат, М.Оюунчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Нямдорж зэрэг гишүүд оролцсон. Мөн Б.Хурцтай холбоотой гомдолтой гэсэн иргэд болох Дамирангийн Энхбатын гэр бүл зэрэг хүмүүс оролцсон.

Нэг элчин сайдыг томилохын төлөө нээлттэй, хаалттай хоёр сонсгол нэгэн зэрэг нэг газар явагдахыг анх удаа харлаа. Түүхэн үйл явдал болсон. Аль нэг элчин сайдын томилгоог хаалттай хэлэлцэхийг эсэргүүцсэн гурван гишүүн байгаа нь Ц.Нямдорж, Л.Оюун-Эрдэнэ, М.Оюунчимэг байсан. Яагаад хоёр сонсгол болсныг МУ-ын их хурлын дарга иргэдэд тайлбарлах ёстой ба үгүй бол их хуралд итгэх үү? үгүй юу? гэдэг асуудал хүчтэй босож ирнэ. Авлигадаа ялагдчихсан улс орны Тагнуулын ерөнхий газрын дарга гэдэг маш их мэдээлэлтэй, төр засгийн шийдвэр гаргагчдын тухай бүх материалыг цуглуулчихсан зөвхөн өөртөө ашигтай үедээ дэлгэдэг үзэгдэл байдаг. Яг л энэ үзэгдэл боллоо л доо. УИХ-ын гишүүд үнэхээр

айсан байсан буюу нээлттэй сонсгол хийнэ гэж 19 хүн гарын үсэг зурснаас хагас нь алга болсон байсан. Тэдгээр хүмүүс айх сандрах их зүйлтэй байгаа гэдгийг харууллаа. Айж сандарсан тэр гишүүд нь Б.Хурцыг хурдхан элчингээр “цөлөхөөр” шийдсэн байна л даа. Бусад оронд ч өөртөө таалагдахгүй, хүчтэй хүмүүсийг элчин маягаар цөлдөг үзэгдэл 17,18-р зууны үед байсан.

Б.Хурцын хувьд их хурлын гишүүдийн тэр мэдээллүүдийг цаг тухайд нь ил гаргаж, арга хэмжээ авч байсан бол МУ ингэж дампуурахгүй, ядуурахгүй, цөөхөн улс төрчид л баяжихгүй байлаа. Та их эрх мэдэлтэй хүн, тэр эрх мэдлээ ашиглаад авлигыг зогсоож, хулгайчдыг барьж илчилсэн бол бид таныг элчин сайд байтугай улсын баатар болгох байлаа.

Хаалттай хурлын өөр нэг шалтгаан нь Б.Хурцыг өөрийнх нь хүсэлтээр чөлөөлөгдөх нөхцлийг тавьсанд байгаа юм. Учир нь Тагнуулын байгууллагын тухай хуульд 14.3 заалтад ТЕГ-ын дарга, дэд даргыг зөвхөн дараах тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө гэсэн байдаг. 1. Өөрөө хүсэлтээ гаргасан 2. Биеийн эрүүл мэндийн байдлаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон 3. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон гэсэн гурван заалт байгаа юм. Гуравхан жил болсон хүнийг солихын тулд ЗГ хэлэлцэж эхлээд л яаж ч чадахгүй болсон шүү дээ. Элчингээр томиллоо гэж хэлээд тушаал гаргамагц нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх гарын үсэг л зуруулж таарсан болов уу гэж бодож байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Засгийн газрын 2017 оны 12 сарын 13-ны өдрийн хуралдаанаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар гэсэн хэрэгжүүлэгч агентлаг шинээр байгуулагдлаа. Энэхүү агентлагийн үйл ажиллагаа ирэх оны 1-р сараас эхлэх бөгөөд Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг байна.

“Нуухыг нь авах гээд нүдийг нь сохоллоо” гэдэг л болж байна. Даатгал уг нь ЗГ-т ямар ч хамаагүй. Даатгалын төлсөн мөнгийг бөөгнүүлээд төлсөн хүмүүс дотроос нь өвдсөн хүнд нь өгдөг систем л дээ. Харин бид даатгалыг төлсөн хүмүүсийг төлөөгүй хүмүүстэй нь цуг бөөгнүүлчихээд бүгдэд нь хуваарилахаар аманд ч үгүй, хамарт ч үгүй болоод байна. Даатгалын мөнгө төлдөггүй хүмүүсийг хадгаламжийн даатгалд нь хамруулаад төр засаг хариуцаад явах нь зүйтэй. Тэтгэврийн даатгал, ЭМД зэрэг даатгалууд нийлээд бие даасан өөрийн сан байх ёстой. Тэр санг мэргэжлийн хүмүүс удирдаад эдийн засгаас хамааралгүйгээр авч явна. Учир нь тэдгээр хүмүүсийн ирээдүйдээ оруулсан хөрөнгө оруулалт нь юм.

Хүн 20 наснаасаа эхлэн даатгал төлж байгаа бол 60 нас хүрээд 40 жилийн турш төлсөн мөнгө байгаа шүү дээ. Энэ мөнгө хамгийн том, хамгийн урт хугацааны мөнгө байдаг учраас тухайн оронд хөрөнгийн зах зээлийг

хөгжүүлэхэд том тоглогч болдог. Энэ сан нь байхгүй учраас хөрөнгийн зах зээл нь байхгүй. Хөрөнгийн зах зээл байхгүй учраас мөнгөний зах зээл буюу нэг жилийн хугацаатай 20-оод хувийн хүүтэй банкны мөнгө бий болчихсон байдаг.

Эрүүл мэндийн салбар хүмүүсийг өвдөхөөр нь эмчилдэг, болж өгвөл өвдөхгүй байхад нь тусалдаг салбар юм. Гэтэл одоо эрүүл мэндийн салбар нэг гараараа үйлчилгээ үзүүлээд, нөгөө гараараа өөртөө төлбөр хийх гээд байгаа байхгүй юу. Эрүүл мэндийн сангаас эмийг үнэгүй олгоход мөнгө олгодог. Гэтэл МУ-д байгаа эмийн 30 хувь нь хуурамч эм гэж байна. Жоргүйгээр эм өгөхийг зөвшөөрөөд нөгөө мөнгөө олгодог учраас монголчууд хоол идэхээ байсан. Одоо бид эм иддэг болсон шүү дээ. Тиймээс Эрүүл мэндийн яам Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг аваад явна гэдэгт итгэх боломж байхгүй.

Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Тоймын бүрэн эхийг
<http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh17-12-17>
холбоосоор үзнэ үү

**NEW NISSAN PATROL**

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:Урьдчилгаа **0%**Хүү **1.4%**Хугацаа **84 сар****УРАМШУУЛАЛ:**

Хамгаалалтын хууца



Салбар сөрөгтэй эрх




4ш. Өмчийн дугуй



Салбарын цалин хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
Баг: Батхүүгийн Амар
Отгонсүрэнгийн Билгүүн
Өсөхбаярын Биндэръяа
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn